



## ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР ИЛТГЭХ ХУУДАС

2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр

Номгон

### 2022 оны хөрөнгийн талаар:


2022 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор нийт 84 байгууллагын 14726,1 сая төгрөгийн өмч хөрөнгөтэй холбоотой Аймгийн ИТХ-ын Хуралдааны тогтоол шийдвэр гарсан. Үүнээс:

Орон нутгийн өмчит 18 байгууллагын 7648,1 сая төгрөгийн хөрөнгөнд эзэмшигч тогтоох, 42 байгууллагын 2486,9 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасах, 11 байгууллагын 2494,0 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, 13 байгууллагын 2096,8 сая төгрөгийн хөрөнгийг худалдах тухай тогтоол гарч хэрэгжилтийг 100% гаргаж ажилласан.

Орон нутгийн өмчит байгууллагын 14 нэрийн хөрөнгийг худалдаж нээлттэй дуудлагын худалдаагаар 70 сая төгрөг, уралдаант шалгаруулалтын аргаар 25,1 сая төгрөг, нийт **95,2 сая** төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг орон нутгийн өмчит 263 байгууллагын 350,4 тэрбум төгрөгийн хөрөнгө тоолж, аймгийн ИТХ-ын Хуралдааны 2023 оны 13/12 тогтоолоор тооллогын дүнг баталгаажуулж ажилласан.

### 2022 онд хөрөнгөтэй холбоотой гарсан тогтоолыг графикаар харуулбал




### 2023 оны хөрөнгийн талаар:

Тогтоол

Аймгийн ИТХ-ын Хуралдааны орон нутгийн өмчит давхардсан тоогоор 340 байгууллагын 29353,5 сая төгрөгийн хөрөнгөнд эзэмшигч тогтоох, 61 байгууллагын 6466,3 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасах, 12 байгууллагын 3021,2 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, 28 байгууллагын 1271,6 сая төгрөгийн хөрөнгийг худалдах тухай тогтоол гарсан.

### Захирамж

Аймгийн ИТХ-ын даргын захирамжаар орон нутгийн өмчит 7 байгууллагын 284 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, 20 байгууллагын 157,5 сая төгрөгийг акталж данснаас хасах, 38 байгууллагын 602 сая төгрөгийн хөрөнгийг худалдах тухай шийдвэр гарсан.



2023 оны 10 дугаар сарын байдлаар нээлттэй дуудлага худалдаагаар 8 нэрийн хөрөнгө худалдаж 42 сая төгрөг, төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн дагуу 23 тээврийн хэрэгсэл худалдаж 243,9 сая төгрөг, уралдаант шалгаруулалтын аргаар 2 нэрийн хөрөнгө хувьчилж 241,7 сая төгрөг, сумдын эргэлтийн эмийн сангуудыг хувьчилж 88,4 сая төгрөг, нийт 614 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.